

**БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ТОХИРЛЫН БАТАЛГААТАЙГААР
ЗАХ ЗЭЭЛД НИЙЛҮҮЛЭХ, УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ****Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журам нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн хуулийн хүрээнд бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор тохирлын баталгаатай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Иргэн, хуулийн этгээд нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13.2-т заасны дагуу “Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт” (цаашид “жагсаалт” гэх)-д заасан бүтээгдэхүүн, үйлчлэгээг тохирлын баталгаажуулалтад заавал хамруулна.

1.3. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд энэхүү журам хамаарахгүй.

1.4. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 14.7-д заасны дагуу Монгол Улсаас олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрээр тохирсон тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг, гэрчилгээтэй бүтээгдэхүүнийг зах зээлд импортоор оруулахад зээлд нийлүүлэх, экспортод гаргах, импортоор оруулахад хяналт, тохирлын үнэлгээнд давтан хамруулахгүй.

1.5. Энэхүү журамд хэрэглэсэн тохирлын үнэлгээтэй холбогдолтой нэр томъёог Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Олон улсын стандартчиллын байгууллага (ISO), Олон улсын цахилгаан техникийн комисс (IEC)-ын арга зүйн удирдамжид заасан утгаар ойлгоно.

1.6. Жагсаалтад зааснаас бусад бүтээгдэхүүн, үйлчилгээг заавал тохирлын баталгаатайгаар зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэхээр хууль, тогтоомж, худалдааны болон бусад гэрээ, хэлэлцээрт тусгасан, эсхүл хүлээн авагч талаас шаардсан бол энэ журмыг баримталж болно.

Хоёр. Тохирлын баталгаа

2.1. Бүтээгдэхүүн, үйлчилгээг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Монгол Улсад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах нийтлэг журам”-ын дагуу тохирлын баталгаажуулалтад хамруулна.

2.3. Жагсаалтад заасан бүтээгдэхүүн, үйлчилгээнд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 15.4-т заасны дагуу итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага тохирлын үнэлгээ хийнэ.

2.4. Жагсаалтад заасан техникийн хяналтад хамруулах үйлчилгээнд итгэмжлэгдсэн техникийн хяналтын байгууллагаас гаргасан дүгнэлтийг үндэслэн итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага тохирлын гэрчилгээг олгоно.

2.5. Аюулгүйн тэмдгийг Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Аюулгүйн тэмдгийн хэлбэр, хэмжээ, хэрэглэх журам”-ын дагуу олгоно.

2.6. Жагсаалтад тусгагдаагүй бүтээгдэхүүнийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь сайн дурын үндсэн дээр тохирлын үнэлгээнд хамруулж, баталгаажуулалтын байгууллага тохирлын гэрчилгээ олгож болно.

2.7. Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Нийлүүлэгчийн мэдэгдлийг гаргах, бүртгэх журам”-ын дагуу гаргасан нийлүүлэгчийн мэдэгдэл нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 14.6-д заасны дагуу тохирлын гэрчилгээний нэгэн адил хүчин төгөлдөр байна.

2.8. Тохирлын үнэлгээг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас эрх авсан баталгаажуулалтын шинжээч хийнэ.

2.9. Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталгаажуулалтын шинжээчийн дүрмийг батална.

Гурав. Бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэх

3.1. Иргэн, хуулийн этгээд нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 14.2-т заасны дагуу хүлээн зөвшөөрсөн тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг, гэрчилгээтэй жагсаалтад заасан бүтээгдэхүүнийг импортоор нийлүүлнэ.

3.2. Энэхүү журмын 3.1-т заасан импортын бараа, бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлтийн өмнөх үе шат дахь хяналтыг дагалдан ирсэн тохирлын үнэлгээний баримт бичиг үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг баталгаажуулалтын шинжээч нотлон шаардлага хангаж байгаа тухай дүгнэлтийг гаалын байгууллагад гаргаж өгч, шаардлага хангасан тохиолдолд гаалийн байгууллага холбогдох журмын дагуу хилээр нэвтрүүлнэ.

3.3. Энэхүү журмын 3.2-т заасан баталгаажуулалтын шинжээчийг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, гаалийн байгууллага зөвшилцөн ажилуулна.

3.4. Хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй импортын бүтээгдэхүүний загварыг нь тохирлын баталгаажуулалтад заавал хамруулахаар Монгол Улсын хууль тогтоомж, бусад эрх зүйн актаар тогтоосон бараа, бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулсны дараа гаалийн байгууллага хилээр нэвтрүүлнэ.

Дөрөв. Бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх

4.1. Иргэн, хуулийн этгээд нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу жагсаалтад заасан бүтээгдэхүүнийг тохирлын баталгаанд хамруулсны дараа зах зээлд нийлүүлнэ.

4.2. Энэ журмын 4.1-д үйлчилгээ болон техникийн хяналт нэгэн адил хамаарна.

4.3. Тохирлын гэрчилгээ олгосон нь түүнийг эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанаас хэрэглэгчид хохирол учруулсан тохиолдолд зохих хариуцлага хүлээлгэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Тав. Тохирлын баталгааны хяналт

5.1. Бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлснээс хойшхи үе шатанд төрийн хяналтыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 29.1-д заасан холбогдох эрх бүхий хуулийн этгээд хэрэгжүүлнэ.

5.2. Иргэн, хуулийн этгээд, төрийн бус байгууллага хэрэглэгчийн зүгээс стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний талаар хэрэгжилтэд хяналт тавьж болох бөгөөд шаардлагтай тохиолдол саналаа холбогдох байгууллагад тавина.

Зургаа. Тохирлын баталгаажуулалтын холбогдох мэдээлэл

6.1. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 14.2-т заасныг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд, мөн хуулийн 16.1 болон 19.3.6-д заасны дагуу итгэмжлэлийн байгууллага нь стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны, гаалийн болон бусад холбогдох иргэн, хуулийн этгээдийг мэдээлэл, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хууль хэрэгжих нөхцлийг бүрдүүлнэ.

6.2. Тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын улсын мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлж, нээлттэй мэдээллийг олон нийт ашиглах нөхцлийг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бүрдүүлж ажиллуулна.

6.3. Итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага болон гаалийн байгууллага бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын болон гаалийн байгууллага хилээр нэвтрүүлсэн чанар, стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүний батлагаа олгосон тухай дүгнэлт, мэдээллийг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага сар бүр хүргүүлнэ.

Долоо. Бусад

7.1. Бүтээгдэхүүний тохирлын баталгаатай холбоотой зөрчилд холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.